



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 11 (536)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг Ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан томилох тухай*

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- *Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 65 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2008 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны гуравдугаар сарын 21

№11 (536)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

147.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 46	238
148.	Баянжаргалын Эрдэнэбаярыг "Шударга журам" медалиар нэхэн шагнах тухай	Дугаар 47	242
149.	Алтангэрэлийн Батболдыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай	Дугаар 48	242
150.	Аюурын Сүрэнжавт Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай	Дугаар 50	242
151.	Рэндоогийн Уртнасанд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай	Дугаар 51	242
152.	Чадраабалын Тунгалагт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай	Дугаар 52	243
153.	Даваахүүгийн Мягмарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 53	243
154.	Намжилын Чинбатад Монгол Улсын гавъяат хуульч цол хүртээх тухай	Дугаар 54	243
155.	Рэгжийбуугийн Нямдоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 55	243
156.	Балдангийн Дариймаад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 56	244
157.	Зарим хүмүүсийг Ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан томилох тухай	Дугаар 61	244
158.	Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлд нэмэлт оруулах тухай	Дугаар 62	244
159.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 63	244

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

160.	"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шалгаруулах тухай	Дугаар 09	245
161.	Хурдан морины зуны бүсийн уралдааны 2008 оны хуваарийг тогтоох тухай	Дугаар 10	245
162.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 23	245

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

163.	Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 65 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай	Дугаар 02	246
------	---	-----------	-----

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар  
хот

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, уул уурхай, дулаан, эрчим хүч, тээвэр, хөдөө аж ахуй, хэвлэл мэдээлэл, төр захиргааны болон

төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Тогоочийн Анигар - Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн эрхлэгч, их эмч

2. Моононгийн Баатарсүх - Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг дарга

3. Дагвын Бадарч - Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

4. Дэндэвийн Батсүх - Ховд аймгийн Үенч сумын өндөр настан, Төр захиргааны байгууллагын ахмад ажилтан

5. Гомбосүрэнгийн Дашдаваа - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Таван Богд" группийн зөвлөх

6. Пунцагийн Доржпагма - Хөгжим бүжгийн коллежийн мэргэжлийн төгөлдөр хуурын багш

7. Оргийн Жамбалдорж - Хууль зүй, Арбитрын яамны сайд асан

8. Цолмонгийн Загдсүрэн - Өмнөговь аймгийн Хөгжимт жүжгийн театрын хөгжмийн удирдаач

9. Хүүхээгийн Лхамцэрэн - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 11 жилийн 6 дугаар сургуулийн зөвлөх багш

10. Сангидоржийн Мөнхдалай - Өвөрхангай аймгийн хэвлэл мэдээллийн "Ноён-Уул" FM радиогийн захирал

11. Ганпүрэвийн Самбуу - ХААИС-ийн мал аж ахуйн тэнхмийн эрхлэгч

12. Орхийн Төмөрсанаа - Увс аймгийн Шуудан холбооны газрын хэвлэл борлуулагч

13. Лхамгарамын Цэдэнсодном - Завхан аймгийн НААҮ-ний "Амь-Ус трейд" ХХК-ийн захирал

14. Лааганы Цэрэнжав - Хөвсгөл аймгийн МАХН-ын хорооны дарга

15. Лувсандоржийн Эрдэнэбаяр - ЭМЯ-ны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал

### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Гэлэгийн Адъяа - МАХН-ын дэргэдэх Ахмадын холбооны гишүүн

2. Гончигжидийн Алтангэрэл - Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

3. Самбуугийн Алтанцэцэг - Арьсны өвчин судлалын төвийн их эмч

4. Хожоогийн Бааст - Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

5. Бадарчийн Баатар - Өвөрхангай аймгийн Төв музейн захирал

6. Жамсрангийн Баатар - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн МАХН-ын 57 дугаар үүрийн дарга

7. Дамиранжавын Баатарсүрэн - Ховд аймгийн Булган сумын Засаг дарга

8. Далайн Бадамсүрэн - Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын Төрийн сангийн төлөөлөгч

9. Сэр-Одын Балжинням - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын багийн Засаг дарга

10. Өөлдийн Бавуу - Сэлэнгэ аймгийн Музейн эрдэм шинжилгээний ажилтан, аймгийн МАХН-ын хорооны тэргүүлэгч

11. Сугаржавын Балчинтуяа - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 11 жилийн 2 дугаар сургуулийн физикийн багш

12. Шаравжамцын Батбаяр - Ардчилсан намын Хэвлэл мэдээллийн албаны дарга

13. Жигжидийн Батжаргал - Төв аймгийн ИТХ-ын дарга



14. Даваасүрэнгийн Батчулуун - Булган аймгийн ЗДТГ-ын дарга, МАХН-ын хорооны тэргүүлэгч

15. Данхүүгийн Баярсайхан - "Монгол-росцветмет" ХХК-ийн харъяа Төв аймаг дахь "Зэрэгцээ" алтны үйлдвэрийн дарга

16. Түвдэнгийн Баярсайхан - Хөвсгөл аймгийн Жаргалант сумын "Мон хас" ХХК-ийн захирал

17. Лувсанжамцын Буяндэлгэр - Сэлэнгэ аймгийн Мандал сумын цэцэрлэгийн эрхлэгч

18. Сандагийн Буянт - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 11 жилийн 2 дугаар сургуулийн бага ангийн багш

19. Цагааны Ганбаатар - Дорноговь аймгийн Засаг даргын орлогч

20. Балжирын Гантуяа - Хэнтий аймгийн Баянхутаг сумын малчин

21. Раднаагийн Ганхуяг - Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын "Дорнод галуут" хоршооны дарга

22. Доржийн Гомбо - Орхон аймгийн өндөр настан, байгаль орчны байгууллагын ахмад ажилтан

23. Довчингийн Даваа - Орхон аймгийн хөдөө аж ахуйн "Олон-Онц" ХХК-ийн захирал

24. Чимэдцэвэгийн Даваажав - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 7 дугаар хорооны өндөр настан, ахмад тээвэрчин

25. Дамдины Данзан - Архангай аймгийн ЗДТГ-ын хүний нөөцийн бодлого хариуцсан ажилтан

26. Дүдэзний Долгорсүрэн - Өвөрхангай аймгийн Тарагт сумын ЗДТГ-ын Төрийн сангийн төлөөлөгч

27. Далайн Должинсүрэн - Нийслэлийн Баянгол дүүргийн 11 жилийн 28 дугаар сургуулийн бага ангийн багш

28. Цаянгийн Дорж - Ховд аймгийн Буянт сумын Ахмадын хорооны дарга

29. Лэгцэгийн Дугарсүрэн - Сүхбаатар аймгийн Уулбаян сумын малчин

30. Даваадоржийн Дэлгэрцогт - Байгаль орчны яамны дэд сайд

31. Намсрайн Жанчив - Баянхонгор аймгийн "Алтанбухт" хоршооны дарга

32. Жүржигийн Лүнжээ - Иргэний зориг намын тэргүүлэгч гишүүн, "Дарь мандал" эмнэлгийн ерөнхий их эмч

33. Раднаабазарын Мандшир - Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын "Баялаг-Үйл-Ундрах" хоршооны дарга

34. Доржийн Намсрай - Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг дарга

35. Доржийн Нансалмаа - Хавдар судлалын үндэсний төвийн их эмч

36. Шаравын Наранцэнд - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн гэмтлийн эмч

37. Шагдарын Норов - Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн чих, хамар хоолойн их эмч

38. Жагваралын Нямбуу - Дархан-Уул аймгийн "Дархан дулааны сүлжээ" ХК-ийн хэлтсийн дарга

39. Бадарчийн Нямсүрэн - Баянхонгор аймгийн Жинст сумын 2 дугаар багийн Засаг дарга

40. Донторын Орго - Дундговь аймгийн Сайнцагаан сумын өндөр настан

41. Намдагийн Орёл - ЭМШУИС-ийн сэтгэцийн эмгэг судлалын тэнхмийн багш

42. Наранхүүгийн Оюун - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын операторч

43. Должингийн Оюунбат - Нийслэлийн Яаралтай тусламжийн төвийн их эмч

44. Зундуйн Оюунчимэг - Дархан-Уул аймгийн Стандартчилал хэмжил зүйн төвийн дарга

45. Банзрагчийн Пунцаг - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дарга

46. Ёндонгийн Самбалхүндэв - ХХААЯ-ны ахлах мэргэжилтэн

47. Жигмэдийн Сүхбаатар - Завхан аймгийн Сонгино сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан

48. Мижидийн Сэрээнэн - Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын орлогч бөгөөд Төрийн сангийн төлөөлөгч

49. Шаравдоржийн Төмөрбаатар - Өмнөговь аймгийн Гзалийн газрын дарга

50. Довдонгийн Уртнасан - Улсын Клиникийн II амаржих газрын сувилагч

51. Хайруллагийн Хусаян - П.Н.Шастины нэрэмжит Клиникийн төв эмнэлгийн Мэдрэлийн мэс заслын тасгийн эрхлэгч

52. Түгэлбайн Хүдэр - Дархан-Уул аймгийн Хонгор сумын өндөр настан, ахмад замчин

53. Гарамын Цэдэндамбаа - Хэнтий аймгийн Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн сургалтын менежер

54. Рэнцэнгийн Цэдэндамба - Төв аймгийн Зуумод сумын өндөр настан, ахмад агрономич

55. Чойнямын Цэрмаа - Нийслэлийн Баянгол дүүргийн "Ган зам" 20 дугаар сургуулийн хими биологийн багш

56. Намжилын Цэцэгбал - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 15 дугаар хорооны нийгмийн ажилтан

57. Баянзулын Цэцэгмаа - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн МАХН-ын 91 дүгээр үүрийн дарга

58. Жанцангийн Чимдрэгээн - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 11 жилийн 24 дүгээр

сургуулийн захирал

59. Готовын Чирчмаа - Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн их эмч

60. Жамбын Шархүү - Говьсүмбэр аймгийн Ахмадын хорооны дарга

61. Хорлоогийн Шархүү - Сэлэнгэ аймгийн Мандал сумын өндөр настан, ахмад багш

62. Бэгзсүрэнгийн Шинэбаатар - Нийслэлийн уул уурхайн "Магнай трейд" ХХК-ийн гүйцэтгэх захирал

63. Ширчинжавын Энхсайхан - Нийслэлийн Налайх дүүргийн МАХН-ын хорооны дарга

64. Машлайн Энхтуяа - Улсын Клиникийн I амаржих газрын тасгийн эрхлэгч

65. Доржийн Эрдэнэчимэг - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Мөнх дөл од" ХХК-ийн захирал

66. Дамдингийн Янжмаа - Завхан аймгийн Сонгино сумын малчин

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Соогийн Адъяа - Сүхбаатар аймгийн Ардчилсан намын дэргэдэх Ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны дэд тэргүүн

2. Баасанцэрэнгийн Алтанцэцэг - НХХЯ-ны мэргэжилтэн

3. Ядамцоогийн Баасанжав - Ардчилсан намын Хэрэг эрхлэх газрын үйлчлэгч

4. Чогровын Банди - Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн улсын байцаагч

5. Жамсранжавын Бадамжав - Орхон аймгийн "Эрдэнэт" цогцолбор сургуулийн гүйцэтгэх захирал

6. Гончигийн Байгалмаа - Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын хүн эмнэлгийн эрхлэгч, их эмч

7. Намхайн Батхүү - Говь-Алтай аймгийн Шарга сумын өндөр настан

8. Дугарсүрэнгийн Баянмөнх - МАХН-ын "Ачлал" амралт, сувиллын газрын дарга

9. Ишдоржийн Баярлах - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 11 жилийн 2 дугаар сургуулийн бага ангийн багш

10. Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ - МАХН-ын Удирдах зөвлөлийн ажлын албаны эрдэм шинжилгээний ажилтан

11. Сугарын Билэгсайхан - Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн тасгийн дарга

12. Лхагвын Бор - Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын сувилагч

13. Авирмэдийн Борхүү - Арьсны өвчин судлалын төвийн асрагч

14. Гомбосүрэнгийн Борхүүхэн - Сүхбаатар аймгийн ҮЭ-ийн холбооны дарга

15. Түмэнбаатарын Бүдээхүү - МАХН-ын хэвлэл "Үнэн" сонины орлогч эрхлэгч

16. Шаравын Буянбилэг - МАХН-ын 2 дугаар байрны үйлчлэгч

17. Чимэд-Осорын Бямбаа - Баянхонгор аймгийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх төвийн биологич

18. Жанчивын Бямбаахүү - МАХН-ын 2 дугаар байрны сантехникийн слесарьчин

19. Аюурзанын Бямбасүрэн - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 11 жилийн 2 дугаар сургуулийн уран зохиолын багш

20. Жигмэдийн Ганбаатар - Архангай аймгийн Хашаат сумын багийн Засаг дарга

21. Даваажавын Даваасүрэн - Орхон аймгийн "Эрдэнэт" цогцолбор сургуулийн бага сургуулийн захирал

22. Чоёнгийн Дашжамц - МАХН-ын диспетчер

23. Дашнямын Жаргал - Дорнод аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга

24. Лодсйн Зимбаа - Завхан аймгийн Яруу сумын багийн бага эмч

25. Бадарчийн Лхансмаа - Говь-Алтай аймгийн Есенбулаг сумын 11 жилийн 2 дугаар сургуулийн бага ангийн багш

26. Санжаагийн Мөнгөнцэцэг - МАСЗХ-ны улс төрийн ажилтан

27. Дашмаагийн Мөнх - Говь-Алтай аймгийн Тайшир сумын малчин

28. Сүхээгийн Мягмар - Баянхонгор аймгийн Баянговь сумын хүн эмнэлгийн их эмч

29. Түмэн-Аюушийн Мягмаржав - УИХ дахь Ардчилсан намын зөвлөлийн ажлын албаны дэд дарга

30. Пүрэвсүрэнгийн Нарантуяа - Ардчилсан Эмэгтэйчүүдийн холбооны нарийн бичгийн дарга

31. Шаравын Ороссүх - Нийслэлийн Ардчилсан намын улс төрийн ажилтан

32. Батсүрэнгийн Оюунбилэг - НХХЯ-ны бичиг хэргийн эрхлэгч-операторч

33. Мялтойгооны Оюунтөгс - МАХН-ын Төв байрны үйлчлэгч

34. Дамбийгийн Оюунчимэг - МАХН-ын Төв байрны үйлчлэгч

35. Ендонжамцын Самдан - Дархан-Уул аймгийн Дархан сумын өндөр настан, ахмад жолооч

36. Дамбажанцангийн Сэнгидорж - Архангай аймгийн Хашаат сумын багийн Засаг дарга

37. Цэндийн Сүнжидмаа - Сүхбаатар аймгийн НААУ-ний "Дөрвөлж" ОНӨҮГ-ын инженер

38. Гомбосүрэнгийн Түмэндэлгэр - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 11 жилийн 2 дугаар сургуулийн бага ангийн багш

39. Мөнхчулууны Түмэнжаргал - Дархан-Уул аймгийн "Дархан дулааны сүлжээ" ХК-ийн жолооч

40. Цэгмэдийн Сэнгээ - Архангай аймгийн Ихтамир сумын багийн Засаг дарга

41. Буджавын Уламбаяр - Дорнод аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн

42. Цэндийн Энхтуяа - Либерал Эмэгтэйчүүдийн оюуны сангийн тэргүүн

43. Дамбадаржаагийн Цэрэндамба - Нийслэл дэх "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн Баруун түгээх төвийн менежер

44. Намсрайн Цэцэндулам - Хөвсгөл аймгийн Рашаант сумын 11 жилийн сургуулийн сургалтын менежер

45. Гэнэнгийн Чулуунбаатар - Хэнтий аймгийн Баян-Овоо сумын малчин

46. Гунгаагийн Элбэг - Их шавийн дээд сургуулийн багш

47. Дамбын Энхбарс - Дорнод аймгийн Баян-Уул сумын дунд сургуулийн захирал

48. Доржхүүгийн Энхтөр - МАХН-ын Удирдах зөвлөлийн ажлын албаны улс төрийн ажилтан

49. Төмөр-Очирын Энхтуяа - НХХЯ-ны Хөдөлмөрийн бодлого зохицуулалтын газрын дарга





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

**Баянжаргалын Эрдэнэбаярыг  
"Шударга журам" медалиар  
нэхэн шагнах тухай**

Эр зориг гарган амь биеэ үл хайрлан голын уснаас бага насны хүүхдийн амь аварч иргэний үүргээ нэр төртэйгээр биелүүлэн алтан амиа алдсан Нийслэлийн Хан-Уул дүүргийн 6 дугаар хорооны иргэн агсан Баянжаргалын Эрдэнэбаярыг "Шударга журам" медалиар нэхэн шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

**Алтангэрэлийн Батболдыг  
"Алтан гадас" одонгоор шагнах  
тухай**

Монгол Улсаа төлөөлөн Антарктид тивийг шинжилгээний ажилтан Алтангэрэлийн Батболдыг судлах олон улсын экспедицед амжилттай ажиллаж "Алтан гадас" одонгоор шагнасугай.

Олон улсын туйл судлалын жилд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Ус цаг уурын хүрээлэнгийн эрдэм

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

**Аюурын Сүрэнжавт Монгол Улсын  
хүний гавъяат эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан, нүдний мэс заслын орчин үеийн шинэ аргуудыг орон нутгийн нөхцөлд чадварлаг нэвтрүүлж, эмнэлгийн эмчилгээ үйлчилгээг сайжруулан, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Увс аймгийн "Нүд" хувийн эмнэлгийн эзэн, их эмч Аюурын Сүрэнжавт хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

**Рэндоогийн Уртнасанд Монгол Улсын  
гавъяат багш цол хүртээх тухай**

Соёл урлаг, боловсролын байгууллагад олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, Монгол Улсад дээд боловсролтой мэргэжлийн жүжигчин бэлтгэх үндэсний сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгож, театрын урлагийн шинэ төрөл хөгжимт театрын жүжигчин бэлтгэх, залуу багш нарыг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж СУИС-ийн тайзны ярианы тэнхимийн эрхлэгч Рэндоогийн Уртнасанд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

**Чадраабалын Тунгалагт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай**

Боловсрол, мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, төгөлдөр хуурын сургалтыг дэлхийн түвшинд хүргэн хөгжмийн урлагийн өндөр зэрэглэлийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, монголын хөгжмийн урлагийг хөгжүүлэх, гадаад оронд сурталчлахад

оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хөгжим бүжгийн коллежийн багш Чадраабалын Тунгалагт Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

**Даваахүүгийн Мягарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай**

Хүнсний аж үйлдвэрийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, үйлдвэрлэлд орчин үеийн шинэ техник технологи нэвтрүүлэн олон нэр төрлийн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, хүнсний аж үйлдвэрийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дундговь

аймгийн үйлдвэр, худалдааны "Мандалговь-Хүнс" ХХК-ийн ерөнхий захирал Даваахүүгийн Мягарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

**Намжилын Чинбатад Монгол Улсын гавъяат хуульч цол хүртээх тухай**

Монгол Улсад хуулийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, иргэний хууль тогтоомжийг боловсронгуй болгон иргэний шүүн таслах ажиллагааг шинэ шатанд гаргах, зах зээлийн эдийн засгийн харилцааны эрх зүйн орчинг бүрдүүлэх, Үндсэн хуулийг хамгаалах болон оюуны өмчийн тогтолцоог боловсронгуй болгоход оруулсан хувь

нэмрийг нь үнэлж Оюуны өмчийн газрын дарга Намжилын Чинбатад Монгол Улсын гавъяат хуульч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

**Рэгжийбуугийн Нямдоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Монголын ард түмний соёлын үнэт өв болсон үндэсний бөхийн уламжлал, ёс горим, түүхийг судлан сурталчилж дэлгэрүүлэх, бөхийн залгамж үеийг тодруулан бэлтгэх, монгол үндэсний бөхийг шинэчлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж Монголын үндэсний бөхийн

холбооны тэргүүн Рэгжийбуугийн Нямдоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

### Балдангийн Дариймаад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

Соёл урлагийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, дархад, хотгойд ардын дууг мэргэжлийн өндөр түвшинд чадварлаг дуулж, урын сангаа баяжуулан, ардын дууны урлагийг өөрийн орон төдийгүй гадаад оронд сурталчлах, хойч үедээ өвлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Хөвсгөл аймгийн хөгжимт драмын театрын дуучин Балдангийн Дариймаад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

### Зарим хүмүүсийг Ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" хуулийн 32 дугаар зүйлийн 32.6 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

шүүхийн Ерөнхий шүүгчийн, Түндэвийн Даваасүрэнг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус улируулан томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

Норовын Лхагвадоржийг Хэнтий аймгийн

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

### Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл"-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын албан тушаалыг цэргийн цолны "бригадын генерал" зэрэглэлтэй байхаар нэмэлт оруулсугай.

2. Энэ зарлигийг гарсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 267 дугаар зарлигаар батлагдсан "Дээд офицерын

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 03 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

### Элчин сайдыг эгүүлэн татах томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь.

Элчин сайд Чойжилжавын Болдыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дашдоржийн Баярхүүг томилсугай.

1. Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шалгаруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2008 онд 40 хүртэлх малчныг "Улсын сайн малчин"-аар, 8 хүртэлх аж ахуйн нэгжийг "Улсын тэргүүний тариаланч хамт олон"-оор, 15 хүртэлх иргэнийг "Улсын тэргүүний тариаланч"-аар тус тус шалгаруулан шагнаусгай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 150 дугаар тогтоолоор

баталсан "Улсын сайн малчин шалгаруулах журам"-ын 2 дугаар заалт, "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шалгаруулах журмын 2 дугаар заалтыг 2008 онд дагаж мөрдөхгүй байхаар тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН САЙД**

**Ц.ГАНХУЯГ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Хурдан морины зуны бүсийн уралдааны 2008 оны хуваарийг тогтоох тухай**

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8.3, Монголын морин спорт, уяачдын холбооны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хурдан морины зуны Төвийн бүсийн уралдааныг Төв аймгийн Заамар суманд 2008 оны 7 дугаар сарын 26-27-ны өдөр, Баруун бүсийн уралдааныг Ховд аймгийн Жаргалант суманд 2008

оны 7 дугаар сарын 26-27-ны өдөр, Зүүн бүсийн уралдааныг Сүхбаатар аймгийн Дарьганга суманд 2008 оны 7 дугаар сарын 31-нээс 8 дугаар сарын 1-ний өдөр тус тус зохион байгуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Н.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

**Хэлэлцээр батлах тухай**

Чикагогийн Иргэний нисэхийн олон улсын конвенци, Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2007 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Арабын Нэгдсэн Эмират Улсын Абу Даби хотноо гарын үсэг зурсан "Монгол Улсын Засгийн газар, Арабын Нэгдсэн Эмират Улсын Засгийн газар

хооронд, тэдгээрийн нутаг дэвсгэрийн хооронд болон хилийн чанадад агаарын харилцаа байгуулах тухай хэлэлцээр"-ийг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Р.РАШ**

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2008 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 65 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим  
15 цаг 00 минут

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд Н.Жанцан, П.Очирбат, Ж.Амарсанаа, Д.Наранчимэг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Ц.Монгол, Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хорооны оршин суугч, иргэн Ш.Пүрэвсүрэн, Дархан-Уул аймгийн Хонгор сумын 336 иргэнийг төлөөлж Дархан-Уул аймгийн Хонгор сумын иргэн Ж.Дэмчигсүрэн, Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дэд дарга О.Даваасамбуу, цэцийн хуралдаанд тайлбар гаргах гэрчээр Гаалийн ерөнхий газрын хэрэг зөрчилтэй тэмцэх хэлтсийн дарга Д.Довчинсүрэн, Улсын мэргэжлийн хяналтын газрын байгаль орчин, геологи уул уурхай, цацрагийн хяналтын газрын дарга Б.Саран, Хүний эрхийн үндэсний комиссын ахлах референт Г.Нарантуяа нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар "Тогтоолд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

"Монгол Улсын Засгийн газрын Тогтоолд нэмэлт оруулах тухай" 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т заасан "Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөнийг тогтоолох,

Засгийн газар нь энэхүү тогтоолыг гаргахдаа уг боомтуудыг мэргэжлийн боловсон хүчнээр болон зориулалтын техник, тоног төхөөрөмжөөр хангаагүй нь Монгол Улсын хилээр их хэмжээний, онц аюултай химийн хор /цианит натри, мөнгөн ус зэрэг/ хяналтгүйгээр нэвтрэх нэг нөхцөлийг бүрдүүлсэн байна." гэжээ.

**Хоёр. Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дэд дарга О.Даваасамбуу Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

...2006 оны 5 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан "Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль"-ийн 15.3 дахь заалтыг үндэслэн Засгийн газар 2006 оны 296 дугаар тогтоолоороо "химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт"-ыг баталсан. Энэ жагсаалтанд Дорноговь аймаг дахь Замын-Үүд, Сэлэнгэ аймаг дахь Алтанбулагийн боомт, мөн аймгийн нутаг дахь Сүхбаатарын боомт, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудлын шалган нэвтрүүлэх боомтууд орсон байна.

**Нэг. Иргэн Ц.Монгол, Ш.Пүрэвсүрэн болон нэр бүхий 336 иргэн Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөлдөө:**

Дээрх тогтоол батлагдсанаар алслагдсан бүс нутгуудад үйл ажиллагаа явуулж буй, үйл ажиллагаандаа зайлшгүй химийн бодис хэрэглэх

шаардлагатай компаниудын хувьд дараах хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Дорнод аймгийн Тамсаг сав газарт үйл ажиллагаа явуулж буй, "Петро Чайна Дачин Тамсаг (Монгол)" ХХК-ийн өрөмдлөг, цооногийн туршилтын үйл ажиллагаанд шаардагдах химийн бодисыг зөвхөн Замын-Үүдийн боомтоор импортлох болсон:

- "Петро Чайна Дачин Тамсаг (Монгол)" ХХК 2006 онд 1200 тонн химийн бодисыг Баянхошуу, Бичигтийн боомтоор тээвэрлэхэд 262 200 ам доллар зарцуулж байсан бол тус компани 2007 онд хайгуулын ажлаа эрчимжүүлж, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэнтэй хэлбэгдэн химийн бодисын хэрэгцээ 2006 оныхоос 5 дахин өссөн. "ПетроЧайна Дачин Тамсаг (Монгол)" ХХК-ийн агуулахаас Замын-Үүд боомт хүртэл 1800-2200 км, Замын-Үүдийн боомтоос Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь Тосон-Уул XIX талбай хүртэл 700-800 км газар тээвэрлэлт хийх шаардлагатай бөгөөд тээврийн зардал 8-9 дахин өсөх тооцоо гарч байсан. Энэ зардал нь өртөгт тосоор нөхөгдөх зардалд орж, уг зардал Монгол Улсын Засгийн газарт ногдох тосоор нөхөгдөх болно.

- "ПетроЧайна Дачин Тамсаг (Монгол)" ХХК-ийн үйл ажиллагаанд шаардагдах химийн бодисыг Замын-Үүдийн боомтоор импортлох нөхцөлд 3 аймаг, нилээд олон сумын нутаг дэвсгэрийг дамжин тээвэрлэлт хийгдэх болж байгаа нь химийн бодисын тээвэрлэлтийн аюулгүй байдал, эрсдлийн хэмжээг ихээхэн нэмэгдүүлэх болсон.

Газрын тосны хайгуулын ажилтай холбоотойгоор Үйлдвэр, худалдааны яамны саналаар Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны 65 дугаар тогтоолоор Дорнод аймгийн Баянхошууны боомт, Сүхбаатар аймгийн Бичигтийн боомтыг тус тус нэмж баталсанаар дээрх хүндрэлтэй асуудал шийдвэрлэгдсэн.

Өнөөдрийн байдлаар Баянхошууны болон Бичигтийн боомтуудаар зөвхөн "ПетроЧайна Дачин

Тамсаг(Монгол)" ХХК нь газрын тосны өрөмдлөг, туршилт үйлчилгээний ажилд зориулан химийн бодисуудыг дараах зөвшөөрлийг үндэслэн импортлож байна. Химийн бодис нь өрөмдлөгийн үйл ажиллагааны технологийн гол материал болдог. Үүнд:

- "ПетроЧайна Дачин Тамсаг(Монгол)" ХХК нь тухайн жил ашиглах химийн бодисын нэр төрөл, хэмжээг тооцож үзсэний үндсэн дээр импортлох химийн бодисын жагсаалтыг холбогдох бичиг баримтын хамт урьдчилан Байгаль орчны яаманд хүргүүлж, зөвшөөрөл авдаг.

- Уг зөвшөөрлийн дагуу химийн бодисыг тээвэрлэн Монгол Улсын хил дээр ирэхэд гаалийн болон хилийн хяналтын байцаагч хил дээр ирсэн химийн бодисуудаас дээж авч Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Гаалийн төв лабораторид илгээн, шинжилгээ хийлгэн, дүгнэлт гаргуулсаны дараа Монгол Улсын хилээр нэвтрүүлдэг. Өөрөөр хэлбэл, гаалийн төв лабораторийн дүгнэлт ирээгүй тохиолдолд химийн бодисуудыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй хил дээр саатуулдаг гэсэн үг.

- Импортоор оруулж ирсэн химийн бодисыг ангилан тусгай зориулалтын агуулахад хадгалдаг бөгөөд тэдгээрийн хадгалалт, ашиглалтын байдалд орон нутгийн болон Улсын мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны байцаагчид тогтмол хяналт тавьж, зөвлөж ажилладаг.

"ПетроЧайна Дачин Тамсаг(Монгол)" ХХК нь 2007 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 2007/53 дугаар зөвшөөрлөөр 72 төрлийн химийн бодис, мөн өдрийн 2007/54 дүгээр зөвшөөрлөөр 47 төрлийн химийн бодис, 2007 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 2007/103 дугаар зөвшөөрлөөр 8 төрлийн химийн бодис, мөн өдрийн 2007/104 дүгээр зөвшөөрлөөр 9 төрлийн химийн бодис, 2007 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 2007/112 дугаар зөвшөөрлөөр 5 төрлийн химийн бодис тус тус импортлосон байна.

Тус компани нь 2007 онд Баянхошууны боомтоор 81 төрлийн химийн бодис, Бичигтийн боомтоор 55 төрлийн химийн бодис импортлох зөвшөөрөл авснаас давхардсан тоогоор нийт 79 төрлийн 6 619 855 кг химийн бодис импортлосон бөгөөд үүнээс 2007 онд 4 512 283 кг химийн бодисыг зарцуулж, 2 227 542 кг химийн бодисын үлдэгдэлтэй байна.

"ПетроЧайна Дачин Тамсаг(Монгол)" ХХК нь химийн бодисын зарцуулалтын тайлангаа хагас жил, жилээр гаргаж Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газарт ирүүлдэг бөгөөд тус агентлаг нь химийн бодисын импорт, хадгалалт, ашиглалт, зарцуулалтын байдалд өөрийн байгууллагын төлөөлөгчөөрөө дамжуулан өдөр тутмын хяналт тавьж ажилладаг.

Газрын тосны ерөмдлөг, цооногийн туршилт үйлчилгээний ажилд шаардагдах химийн бодисууд нь маш нарийн журам, өндөр хяналтан дор импортлогдож, хадгалагдаж, ашиглагддаг.

Импортлож буй химийн бодисуудыг тухай бүр Гаалийн төв лабораторид шинжлүүлдэг тухай дээр дурьдсан бөгөөд шинжилгээний дүнгээр калийн усан исэл, натрийн сульфат, хос калийн перьсульфат, барийн сульфат, кальцийн карбонат гэсэн 5 химийн бодис үйлдвэрлэлийн зориулалттай, хүчтэй үйлчилгээтэй хорт бодисууд, бусад нь үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэгдэх химийн бодис ба бэлдмэлүүд болох нь тодорхойлогдсон байдаг.

Газрын тосны ерөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглаж буй химийн бодисууд, шавар болон шингэнүүд нь цооногийн ханын нуралт үүсэх, хэт халах, зуулт үүсэх, ерөмдлөгийн явцад тос оргилон гарахаас хамгаалах, мөн чулуулгийн нүх сүв, ан цавыг сэргээх, ундаргыг нэмэгдүүлэх, тундасжсан давсыг задлах зэрэг технологийн шаардлагатай бөгөөд эдгээр шингэнүүд, химийн бодисуудыг цооногт 2500-3000 метрийн гүнд шахдаг, түүнийг эргүүлэн газрын гадаргууд буцаан

гаргадаггүй. Энэ нь бусад ашигт малтмалын олборлолт, ноос ноолуур угаах гэх мэт хөнгөн аж үйлдвэрийн салбарт химийн бодисыг ашиглаж буй арга технологигоос эрс ялгаатай юм. Газрын тосны үйл ажиллагаанд ашиглагдаж буй химийн бодис, хаягдал нь газрын гадаргуу, гол мөрөн, нуур цөөрөм, усан санд орох нөлөөлөлгүй юм.

Өргөдөлд дурьдаад байгаа цианид натри, мөнгөн ус нь алт цэвэршүүлэхэд хэрэглэгддэг химийн бодис бөгөөд тэдгээрийг газрын тосны ерөмдлөгийн болон туршилт үйлчилгээний ажилд огт хэрэглэдэггүй төдийгүй Баянхошууны, Бичигтийн боомтуудаар цианит натри, мөнгөн усыг импортлож байгаагүй, цаашид ч дээрх боомтуудаар цианит натри, мөнгөн усыг импортлохгүй болно. Монгол Улсын Засгийн газар Монгол улсад ашиглах химийн бодисын нэр төрөл, тоо хэмжээнд хяналт тавих, хортой, аюултай бодисыг ашиглахыг хориглох, хязгаарлах зорилгоор "Монгол улсад ашиглахыг хориглосон буюу хязгаарласан химийн бодисын жагсаалт"-ыг 2007 оны 95 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, уг жагсаалтад 30 бодис хэмрагдаж байсныг бодит байдалд нийцүүлэн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой 111 бодисыг оруулсан бөгөөд эдгээрээс 28 бодисын ашиглалтыг хязгаарлаж, үлдсэн 83-г бүрмөсөн хориглохоор шийдвэрлэсэн юм. Үүний дотор мөнгөн ус болон натрийн цианидыг Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн бодисын жагсаалтад багтаасан ба тэдгээр бодисыг зөвхөн тодорхой зорилгоор, тодорхой тоо хэмжээгээр импортлож, ашиглаж байхаар тусгасан байдаг.

Иймд өргөдөлд дурьдаад байгаа цианит натри, мөнгөн усыг Баянхошууны болон Бичигтийн боомтуудаар огт оруулж ирдэггүй бөгөөд Засгийн газрын 95 дугаар тогтоолоор мөнгөн ус болон натрийн цианидыг Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн бодисын жагсаалтад багтаасан ба тэдгээр бодисыг зөвхөн тодорхой зорилгоор, тодорхой тоо хэмжээгээр импортлож, ашиглаж байхаар тусгасан байх тул Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны



өдрийн 65 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэх үндэслэлгүй байх тул иргэн Ц.Монгол, Ш.Пүрэвсүрэн нарын шаардлагыг хэрэгсэхгүй болгож өгнө үү... гэжээ.

**Гурав. Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Үйлдвэр худалдааны дэд сайд Я.Содбаатар 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

С ...Монгол Улсын Засгийн Газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоол нь "Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалтыг батлах тухай" бөгөөд химийн болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт батлах тухай Засгийн газрын 2006 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 296 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд:

*Д/ Дорнод аймаг дахь Баянхошууны боомт*

*Е/ Сүхбаатар аймаг дахь Бичигтийн боомт...гэсэн заалтыг нэмж оруулсан байгаа юм.*

Засгийн газрын тогтоолд нэмэлт оруулах тухай энэхүү тогтоол нь хүний эрх, эрх чөлөөний эсрэг заалтгүй болно.

Дээрх нэр бүхий иргэд тогтоолын энэхүү нэмэлт өөрчлөлтийг Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 2-т заасан "Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, эрх чөлөөг... нь" зөрчсөн гэж чухам ямар учраас үзэх болсон нь ойлгомжгүй байна. Тэдний бичсэн өргөдөлд Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоолын улмаас хаанахын иргэдийн эрх, эрх чөлөө хэрхэн зөрчигдөж, ямар хохирол учирсан талаар дурьдаагүй байх бөгөөд Хонгорын иргэдийн эрхийг зөрчсөн гэж үзэж байгаа бол тэдэнд хэний буруутай үйл ажиллагаанаас ямар хохирол учирсныг нарийвчлан тогтоогоогүй, энэ талаар мэргэжлийн байгууллагын болон /олон

улсын/ шинжээчдийн дүгнэлт хараахан гараагүй байна.

"Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай" хуульд зааснаар иргэн өөрийн шаардлагын үндэслэл, бусад нөхцөл байдал, тэдгээрийн нотолгоог гаргаж өгсөн байх ёстой бөгөөд иргэн Ц.Монгол, Ш.Пүрэвсүрэн нар нь энэ удаа ямар ч нотолгоо баримтгүйгээр асуудлыг дутуу дулимаг судалж тавьсан байна.

Дорнод аймаг дахь Баянхошууны болон Сүхбаатар аймаг дахь Бичигтийн боомтуудыг нээж ажиллуулах болсноор Дархан-Уул аймгийн Хонгор сумын иргэд хордсон гэж өнгөцхөн авч үзэх нь учир дутагдалтай болно.

Аль ч улс орон хилээрээ химийн хортой болон аюултай бодисыг оруулахыг огт зөвшөөрөхгүй, хориглосон байдаггүй нь түүнийг хяналттайгаар ашиглах шаардлага байдагтай холбоотой юм.

Манай улсын хувьд ч 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан "Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль"-ийн 15.3 заалтыг үндэслэн 2006 оны 12 дугаар сарын 19-ний өдөр химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газрын 296 дугаар тогтоолоор баталсан байна. Тэдний үзэж буйгаар Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байгаа бол үүнтэй ижил утга бүхий улсын хилээр химийн хорт болон аюултай бодисыг нэвтрүүлэх тухай бусад тогтоолуудыг хэрхэн үзэх вэ гэдэг асуудал гарч ирэх болно.

Байгууллага, хувь хүний хууль бус үйл ажиллагаанаас буй болсон нийгэм, ард иргэдэд аюултай хор уршиг бий болсон тэр хоёрын хоорондох бодит холбоог шалтгаант холбоо гэж үздэг бөгөөд өргөдөлд дурьдсан Засгийн газрын тогтоол гарснаар Дархан-Уул аймгийн Хонгор



сумын иргэд хохирсон гэж үзэх хоёрын хооронд шууд шалтгаант холбоо байхгүй байна. Тэгээд ч Хонгор суманд тархсан гэх цианит натри, мөнгөн ус мэтийн химийн хорт бодисууд нь тогтоолд дурьдсан хоёр боомтоор огтоос орж ирээгүй болох нь Датамо ХХК Тамсагийн сав газарт газрын тосны үйл ажиллагаанд ашиглах химийн бодисыг жагсаалт, бусад баримтуудаас тодорхой болно. Цианит натри, мөнгөн ус зэрэг нь алтыг цэвэршүүлэх зориулалттайгаар хэрэглэдэг химийн бодис тул газрын тос олборлолтонд ашиглагддаггүй.

Монгол Улсын Засгийн газрын баталсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний дагуу Дорнод аймгийн Тамсагийн сав газарт газрын тосны хайгуул, олборлолт, тээвэрлэлт, экспортын "ПетроЧайна Дачин Тамсаг (Монгол)" ХХК нь үйл ажиллагаагаа явуулж байна. "ПетроЧайна Дачин Тамсаг (Монгол)" ХХК нь 2007 онд хөрөнгө оруулалтаа 140 сая ам.доллар хүртэл нэмэгдүүлж, хайгуул, үнэлгээний 100 гаруй цооног өрөмдөхөөр төлөвлөсөн бөгөөд химийн бодисын хэрэгцээ 2006 оныхоос 3 дахин өсөхтэй холбоотой Дорнод аймгийн Матад, Халхгол сумдын нутаг дахь газрын тосны хайгуулын талбай хүртэл Баянхошуу, Бичигтийн боомтуудаар импортлоход тээвэрлэлт 200 орчим км замыг туулдаг бол Замын-Үүдийн боомтоор нэвтрүүлэхэд 700-800 км болж, тээврийн зардал нь 8-9 дахин өсөхөд хүрэх тооцоо гарчээ. Тус компанийн 2007 онд ашиглах нийт химийн бодисыг Замын-Үүдийн боомтоор импортлоход 1,951,000 ам.долларын тээврийн зардал гарах байсан бол нэр бүхий хоёр боомтуудаар оруулахад тээвэрлэлтэд 786500 ам.долларын зардал гарч өртөгт тосоор нөхөгдөх зардлын хэмжээ 1,2 сая орчим ам.доллараар хэмнэгдэх юм. Уг өртөгт тосоор нөхөгдөх зардал нь Монгол Улсын Засгийн газарт ногдох тосоор эргэн төлөгддөг.

Баянхошуу, Бичигтийн боомтуудаар химийн бодисыг нэвтрүүлэхэд тээвэрлэлт зөвхөн нэг буюу хоёр аймгийн нутаг дэвсгэрээр дамждаг бол 3 аймаг, олон сумын нутаг дэвсгэрийг дамжин Замын-Үүдийн боомтоор оруулах нь химийн бодис

тээвэрлэлтийн аюулгүй байдал, эрсдлийн хэмжээг нэмэгдүүлэх аюултай байв.

Химийн бодисыг олон салбарт хэрэглэдэгээс газрын тосны өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглах зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ тохиолдолд химийн бодисыг цооногт 2500-3000 метрийн гүнд шахдаг, түүнийг эргүүлэн газрын гадаргууд буцаан гаргадаггүйгээс газрын тосны үйл ажиллагаанд ашиглагдаж буй химийн бодис, хаягдал нь газрын гадаргуу, гол мөрөн, нуур цөөрөм, усан санд орох нөлөөлөлгүй юм.

"ПетроЧайна Дачин Тамсаг (Монгол)" ХХК-д учирсан дээрх бэрхшээлтэй байдлууд, газрын тосны үйл ажиллагааны технологийн онцлог нөхцөл байдал зэргийг харгалзан үзэж, Монгол Улсын Засгийн газар 2006 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 296 дугаар тогтоолын 1 дүгээрт заасан химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалтанд Дорнод аймаг дахь Баянхошуу-Өвдөгийн боомт, Сүхбаатар аймаг дахь Бичигт-Зүүн хатавчийн боомтуудыг нэмж оруулах шаардлага бий болсон юм.

Газрын тосны үйл ажиллагаанд ашигладаг химийн бодис, реагентийг зөвхөн өрөмдлөгийн ажилд хэрэглэдэг бөгөөд эдгээр нь өрөмдлөгийн технологийн гол материал болдог юм. Тус компани нь 2006 онд 30 гаруй төрлийн химийн бодис, реагентүүдийг холбогдох байгууллагаас зөвшөөрөл аван, Гаалийн төв лабораторид шинжилгээ хийлгэж, Дорнод аймгийн нутаг дахь Баянхошууны боомт, Сүхбаатар аймгийн нутаг дахь Бичигтийн боомтоор Монгол улсын нутаг дэвсгэр рүү оруулж ашигласан бөгөөд өнөөг хүртэл зөрчил гаргаж байгаагүй болно.

Тус компани нь Байгаль орчны яам, Улсын мэргэжлийн хяналтын газраас тавьсан шаардлагын дагуу Тамсагийн сав газарт ажиллаж байгаа өрөмдлөгийн анги, бригад бүрийг химийн бодис хадгалах тусгай сав, агуулахтай болгосон бөгөөд химийн бодисын зарцуулалтын тайланг гаргаж,



холбогдох байгууллагуудад хүргүүлдэг журам тогтоогоод байна. Мөн химийн хортой бодис бүхий ермийн шингэнийг хөрсөнд үл нэвчүүлэх материалаар хийгдсэн хамгаалалтын дэвсгэр бүхий зумфэнд хадгалж, тосыг соруулж, тос арилгах бактери, байгалийн шүү ашиглах замаар цэвэршүүлэх, хатаах аргаар байгаль орчинд сөрөг нөлөөгүй болгож байна.

Газрын тосны үйл ажиллагаанд ашигладаг химийн бодисуудыг дотор нь химийн хортой ба хоргүй гэж ялгадаг. "ПетроЧайна Дачин Тамсаг (Монгол)" ХХК болон түүний туслан гүйцэтгэгч компаниудын ерөмдлөгийн үйл ажиллагаанд ашигладаг химийн бодисуудын зөвхөн 8 орчим хуви нь химийн хортой бодис, бусад нь үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэгдэх химийн хоргүй бодис ба бэлдмэлүүд юм. 2006 онд тус компанийн импортлосон химийн бодисуудыг Гаалийн төв лабораторид шинжлүүлэхэд калийн усан исэл, натрийн сульфат, калийн персульфат гэсэн 3 төрлийн бодис нь үйлдвэрлэлийн зориулалттай, хүчтэй үйлчилгээтэй хорт бодисууд, бусад нь үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэгдэх химийн бодис ба бэлдмэлүүд болох нь тодорхойлогдсон.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй тул иргэн Ц.Монгол Ш.Пүрэвсүрэн нарын тавьсан шаардлагыг хэрэгсэхгүй болгож өгнө үү... гэжээ.

**Дөрөв. Гаалийн ерөнхий газраас 2007 оны 12 дугаар сарын 19-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн 08/5649 тоот албан бичигт:**

...Дорнод аймаг дахь Баянхошуу, Сүхбаатар аймаг дахь Бичигтийн хилийн боомтуудаар 2007 оны 03 дугаар сараас өнөөдрийг хүртэл 1762,572 тн химийн бодис "ПетроЧайна Дачин Тамсаг" ХХК, "Дачин Тамсаг Монгол" ХХК-иудын нэрээр орж, гаалийн бүрдүүлэлт хийгдсэн байна.

Замын-Үүд, Сэлэнгэ, Алтанбулаг боомтууд дээр өнөөдрийн байдлаар бүрэн тоноглогдсон лаборатори байдаггүй, Улаанбаатар хотод байрлалтай гаалийн төв лабораторт дээж сорьцыг нь авчран шинжлүүлж байгаа бөгөөд Дорнод аймаг дахь Баянхошуу, Сүхбаатар аймаг дахь Бичигтийн боомтууд дээр үүнтэй адилаар гаалийн хяналт тавигдаж байна.

2007 онд Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхошуу дахь гаалийн салбар 5, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн хороо 13 хүний орон тоотой ажиллажээ... гэжээ.

**Тав. Улсын мөрдөн бгцлэх газраас 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн 10/1-7072 тоот албан бичигтээ:**

...Химийн цианит, натри, мөнгөн ус зэрэг хорт бодисыг хууль бусаар ашигласнаар Дархан-Уул аймгийн Хонгор суманд ард иргэд, мал, газар, хордсон мэдээллийн дагуу Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасагт "Цагаан бүрд" ХХК-ний захирал Д.Тунгалаг нарын 4 хүнд /БНХАУ-ын иргэд/ Эрүүгийн хуулийн 200 дугаар зүйлийн 200.3-т зааснаар эрүү үүсгэн шалгалт хийжээ.

Эрүүгийн 20723299 тоот Д.Тунгалаг нарт холбогдох хэргийн шалгалтаар ард иргэд болон мал хөрөнгөнд 51 сая төгрөгний хохирол хорт бодисыг хууль бусаар хэрэглэснээс үүссэн нь тогтоогдож, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар хэргийг прокурорт шилжүүлсэн байна.

Мөн Улсын мөрдөн байцаах газрын 5 дугаар хэлтэст Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутаг Цагаан цахир гэдэг газар "Цагаан цахир Гоульд"-ын хаягдлын далангаас цианиттай ус урсаж ямаа үхлээ гэсэн мэдээллээр Эрүүгийн хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-т зааснаар 2006 оны 10 дугаар сарын 31-нд эрүү үүсгэн шалгажээ.

Эрүүгийн 20603319 тоот БНХАУ-ын иргэн, Хау Шин Ян, Чой Юн Хэ нарт холбогдох эрүүгийн хэргийг шалгахад цианит, амонит, хар тугалга уурхайн хаягдал усанд илэрч түүнээс 64 ямаа хордож үхсэн нь шалгалтаар тогтоогдсон тул яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар хэргийг прокурорт шилжүүлсэн байна... гэжээ.

## ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 65 дугаар тогтоолоор Засгийн газрын 2006 оны 296 дугаар тогтоолын 1 дэх заалтад Дорнод аймаг дахь Баянхошууны боомт, Сүхбаатар аймаг дахь Бичигтийн боомтыг "химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх" боомтын жагсаалтад оруулсан нь Монгол Улсын Засгийн газрын эрх хэмжээний асуудал бөгөөд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2/, Гучин наймдугаар зүйлийн 1, Гучин наймдугаар зүйлийн 2-ын 4/, Гучин наймдугаар зүйлийн 2-ын 7/ дахь заалтыг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Дээрх боомтуудаар химийн онц аюултай хорт бодис цианит натри, мөнгөн ус нэвтрүүлсэн гэх үндэслэл, нотолгоо тогтоогдохгүй байна.

3. Өргөдөл гаргагчаас хуралдааны явцад гаргасан нэмэлт шаардлагын талаар үндсэн хуулийн цэц урьдчилан шалгалт хийж маргаан хянан шалгах ажиллагаа үүсгээгүй тул дүгнэлт гаргах боломжгүй гэж үзэв.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. "Монгол Улсын Засгийн газрын "Тогтоолд нэмэлт оруулах тухай" 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2/ дахь хэсгийн "Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй", Гучин наймдугаар зүйлийн 1-ийн "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн", Гучин наймдугаар зүйлийн 2-ын 4/-ийн "хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах", Гучин наймдугаар зүйлийн 2-ын 7/-ийн "хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх" гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг 2008 оны Улсын Их Хурлын хаврын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Ж.БЯМБАДОРЖ**

**ГИШҮҮД**

**Н.ЖАНЦАН**

**П.ОЧИРБАТ**

**Ж.АМАРСАНАА**

**Д.НАРАНЧИМЭГ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265958  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 2